**МОНГОЛ УЛС**
**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 02 өдөр Дугаар А/318 Мөрөн сум

Дуудлага худалдаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21, Амьтны тухай хуулийн 29[1] дүгээр зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх заалт, 8.1 дүгээр зүйлийн 1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдаа зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар байгуулсугай.

2. Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрөл олгох дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийн ажиллах дүрмийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Тусгай зориулалтаар агнуурын амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох дуудлага худалдааг хууль, журманд нийцүүлэн зохион байгуулж, дуудлага худалдааны тайлан мэдээг тайлагнахыг ажлын хэсэг (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6710010003

Аймгийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн
А/318 тоот захирамжийн нэгдүгээр
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлстийн дарга)

Гишүүдэд:
П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Б.Болд (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ё.Батсайхан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Х.Энхтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн мэдээлэл, харилцаа холбооны хяналтын Улсын байцаагч)

Хөтлөгч: А.Энхжаргал (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч: Д.Даваадорж (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэн)

_____oOo_____

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар
02-ны өдрийн А/318 тоот захирамжийн
хоёрдугаар хавсралт

# ТУСГАЙ ЗОРИУЛАЛТААР АГНУУРЫН АМЬТАН АГНАХ, БАРИХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ДҮРЭМ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

1.1.Энэ журмаар Амьтны тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих зөвшөөрлийг олгохтой холбоотой дуудлага худалдаа зохион байгуулахад оршино.

1.2. Хөвсгөл аймгийн Засаг дарга (цаашид "зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд" гэх) нь тусгай зориулалтаар ан амьтныг агнах, барих зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх) байгууллагаас баталсан гэрчилгээгээр олгоно.

1.3. Тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох дуудлага худалдааг аймгийн Засаг даргын Тамгын газарт (цаашид “дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг” гэх) нь зохион байгуулна.

1.4.Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд ховор загас барих дуудлага худалдааг аймгийн Засаг даргын Тамгын газарт (цаашид “дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг” гэх) нь зохион байгуулж гэрээг Улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа байгуулна.

1.5. Тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих дуудлага худалдаа зохион байгуулах талаар гарсан хууль, тогтоомж, тушаал шийдвэрийн заалтуудыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангах, хамтран зохион байгуулах.

## ХОЁР. АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛЛАХ ЗАРЧИМ

2.1. Ажлын хэсэг дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.1.1. Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг нь ажлын хэсгийн ахлагч, хөтлөгч, тэмдэглэл хөтлөгч, гишүүдээс бүрдэнэ.

2.1.2. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэж, оролцогч бүрт дугаар бүхий пайз олгоно.

2.1.3. Ажлын хэсэг нь дуудлага худалдаа зохион байгуулсан ажлын талаар тухай бүрд нь тайлагнаж ажиллана.

2.1.4. Ажлын хэсгийг шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь зарлан хуралдуулж болно.

2.1.5. Ажлын хэсгээс гарах шийдвэр хурлын тэмдэглэл байна.

2.2. Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн дарга дараах эрх үүрэгтэй.

2.2.1. Дуудлага худалдааг зохион байгуулж явуулахтай холбогдсон хууль тогтоомж, журмын заалт, тусгай зориулалтаар агнах, барих амьтны тухай шийдвэр, дуудлагын

худалдааг зохион байгуулж явуулах ажлын хэсгийг томилсон шийдвэрийг танилцуулж, дуудлагын худалдаа эхэлснийг мэдэгдэнэ.

2.2.2. Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч эрх үүргээ ажлын хэсгийн нэг гишүүнд шилжүүлж дуудлага худалдааг зохион байгуулж болно.

2.2.3 Дуудлага худалдааны тэмдэглэлийг хянаж гарын үсэг зурна.

2.3. Дуудлага худалдааны хөтлөгч дараах эрх үүрэгтэй.

2.3.1. Үнэ хаялцах хамгийн дээд болон доод үнийг зарлаж, дуудлагын хуралдааны тэмдэглэлд тусгах

2.3.2. Дуудлагын худалдаа эхэлснийг зарлан мэдээлсний дараа үнэ хаялцах ажиллагааг эхлүүлэн дуудлага худалдаанд оролцогчдийн үнийн саналыг пайз өргөсөн дараалаар дуудах.

2.3.3. Дуудлага худалдаанд оролцогчийн үнийн саналыг гурван удаа давтаж хэлэх.

2.3.4. Хамгийн сүүлийн үнийн саналыг гурван удаа давтан дуудаж "буулаа нэг, хоёр, гурав" гэж тоолсоны дараа шинээр үнийн санал гараагүй бол тусгай дохиогоор дуусгавар болгон ялагчийг зарлан мэдээлнэ.

2.3.5. Дуудлага худалдааны тэмдэглэлийг хянан үзэж гарын үсэг зурна.

2.4. Дуудлага худалдааны тэмдэглэл хөтлөгч дараах эрх үүрэгтэй.

2.4.1. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх

2.4.2. Дуудлага худалдаа зохион байгуулах явцын тэмдэглэлийг маягтын дагуу үнэн зөв, бүрэн хөтлөх.

2.4.3. Дуудлага худалдааны үнэ хаялцах дээд болон доод хязгаарыг дуудлага худалдааны тэмдэглэлд тусгах.

2.4.4.Дуудлага худалдаанд оролцогчдын үнийн саналыг пайз өргөсөн дараалаар явцын тэмдэглэлд бичих,

2.4.5. Дуудлага худалдааны тэмдэглэлд гарын үсэг зурна.

2.5. Дуудлага худалдааны ажлын хэсгийн гишүүн дараах эрх үүрэгтэй

2.5.1. Дуудлага худалдаанд санал гаргаж үг хэлж болно.

2.5.2. Дуудлага худалдааны тэмдэглэлд гарын үсэг зурна.

## ГУРАВ. ДУУДЛАГА ХУДАЛДАА ЯВУУЛАХ ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН

3.1. Тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих дуудлага худалдаа зохион байгуулах цахим мэдээллийн сан нь дараахь мэдээллээс бүрдэнэ:

## ДӨРӨВ. ДУУДЛАГА ХУДАЛДААГ ЗАРЛАН МЭДЭЭЛЭХ.

4.1. Дуудлага худалдааны зар мэдээг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сайтаар дамжуулан зарлана.

4.2. Дуудлага худалдааны шалгаруулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд зохион байгуулна.

4.3. Дуудлага худалдааг тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих тоо хэмжээг голын сав дагуу сумдад хуваарилан 1 дул загас барьж буцаан тавих зөвшөөрлийг дагуулж 10 хүртэл жижиг загасыг дагуулж зарлана.

## ТАВ. ДУУДЛАГА ХУДАЛДААГ ДУУСГАВАР БОЛГОХ.

5.1. Дуудлага худалдааг үнэ хаялцуулж дуусаны дараа дохио өгч хааснаар дуусгавар болсонд тооцно.

5.2. Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнэ өгсөн ялагчтай тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих гэрээ байгуулна.

5.3. Улсын тусгай хамгаалалттай газарт ховор загас барих дуудлага худалдаанд хамгийн өндөр үнэ өгсөн ялагчтай тусгай зориулалтаар ан амьтан агнах, барих гэрээг Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа байгуулна.

## ЗУРГАА. ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЯВЦАД ҮҮССЭН МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

6.1. Дуудлага худалдааны явцад үүссэн маргааныг ажлын хэсэг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэнэ. Ажлын хэсгийн шийдвэрийг зөвшөөрөхгүй бол дээд шатны байгууллага болон шүүхэд гомдол гаргаж болно.

## ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Дуудлага худалдаа зохион байгуулах хууль журмыг зөрчиж зохион байгуулсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

_____oOo_____